

ЭХЭМҮТ-ИЙН ЭЗЭМШИЛД ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛБАЙ ТҮРЭЭСЛЭХ ТАЛБАЙН ТАНИЛЦУУЛГА

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эзэмшлийн талбайд худалдаа үйлчилгээний зориулалттай талбай түрээслэн ажиллуулах түрээслэгчийг сонгох сонгон шалгаруулалтад Монгол Улсын хуулийн этгээдийг сонгон шалгаруулалтад урьж байна.

1. Сонгон шалгаруулалтын нэр

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эзэмшилд байрлах худалдаа үйлчилгээний зориулалттай талбайг түрээслэн ажиллуулах сонирхолтой Монгол Улсын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах.

Шалгаруулалтад оролцогч хуулийн этгээд нь сонгон шалгаруулалтын материалыг БГД, 11-р хороо, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв байр, Захиргааны 4 давхар, Бичиг хэргийн ажилтанд битүүмжлэн ирүүлсэн байна.

Материалыг зарласан хугацаанд байгууллагын нэр, байршил, зориулалт, бүрдүүлсэн материалын жагсаалт тус бүрийг дугтуйны гадна талд товъёог хийж битүүмжилсэн хэлбэрээр 2 хувь (эх болон хуулбар хувь) ирүүлнэ.

2. Түрээслүүлэх эд хөрөнгийн танилцуулга

д/д	Түрээслэх талбайн зориулалт	Байршил	Талбайн хэмжээ	Талбайн түрээсийн сарын доод үнэ /1 м.кв/
1	Худалдаа үйлчилгээ	Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн нэг давхар	28 м.кв	35,000
2	Худалдаа үйлчилгээ	Хүүхдийн эмнэлгийн нэг давхар	48 м.кв	35,000

3. Сонгон шалгаруулалтын ерөнхий мэдээлэл

Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 49, 50, 51 дүгээр тогтоолуудыг тус тус үндэслэн түрээслэгч сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод зохион байгуулна.

Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа	2026 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 10 цаг хүртэл
Материал хүлээн авах хаяг	БГД, 11-р хороо, Эх, Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв байр, Захиргааны 4 давхар, Бичиг хэрэг

Материал нээх хугацаа, хаяг байршил	2026 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 10 цаг 30 минут, БГД, 11-р хороо, Эх, Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв байр, Захиргааны 4 давхар, хурлын зааланд нээнэ.
Эд хөрөнгө түрээслэх үнийн доод хэмжээ	1 м.кв – 35,000 төгрөг
Түрээслэгч үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийн мэдээлэл	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг нотариатаар баталгаажуулсан хуулбар ирүүлэх
Монгол Улсын хуулийн этгээдэд дараах нэмэлт шаардлага тавигдана	• Татварын өр төлбөргүй байх. • Татварын тодорхойлолт ирүүлнэ /etax.mta.mn/ • Худалдаа үйлчилгээ үзүүлэхэд стандартын шаардлага хангасан засвар тохижилтыг гүйцэтгэгч байгууллага өөрийн хөрөнгөөр буцаах нөхцөлгүйгээр гүйцэтгэнэ. Энэ тухай албан бичгээр ирүүлнэ. • Талбайн өдөр тутмын засвар үйлчилгээг хариуцах чадвартай байх (нотлох баримт хавсаргах) • Гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд аж ахуйн нэгжийн байршуулах барьцаа хөрөнгө нь тухайн байр талбайн 1 сарын хөлслүүлэх хэмжээтэй тэнцүү байна. Энэ тухай мэдэгдсэн албан бичиг ирүүлэх. • Ашигласан гэрэл цахилгаан цэвэр бохир ус, халаалт, хог хаягдал гэх зэрэг хэрэглээний төлбөрийг сар бүр тоолуурын заалтын дагуу төлөх үүргийг албан бичгээр ирүүлнэ. • Хуулийн этгээд худалдаа үйлчилгээний зориулалтаар түрээслэх нэг байршилд үнийн санал ирүүлнэ.
Оролцогчдын бүрдүүлж ирүүлэх материал	• Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй бол тус тус нотариатаар баталгаажуулсан хуулбар ирүүлнэ. • Үйл ажиллагааны танилцуулга, ажлын туршлагын талаарх сүүлийн 2 жилийн мэдээлэл; /өмнө нь хийж гүйцэтгэсэн ажлын гэрээ, нотлох баримтын хамт/ • Өмнө гүйцэтгэсэн ажлын талаарх харилцагч байгууллагын тодорхойлолт, тооцоо нийлсэн актын хуулбарын хамт • Санхүүгийн чадварыг нотлох сүүлийн 1 жилийн хураангуй дансны хуулга, мөнгө болон хөрвөх чадвартай хөрөнгө, үйл ажиллагаа эхлүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг нотлох баримт (Дансны

	хуулга болон зээл авах боломжтой мэдээлэл ирүүлэх) • 2024, 2025 оны жилийн аудитлагдсан тайлан ирүүлэх • Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын шүүхээр тогтоогдсон бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт /E-mongolia лавлагаа/; • Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн сүүлийн 1 жил (2025.08-2026.08 сар)-ийн тодорхойлолт /E-mongolia лавлагаа/; • Ажиллах хүчний мэдээлэл, мэргэжлийн диплом иргэний үнэмлэхийн хуулбар; сүүлийн 1 жил тухайн байгууллагад төлсөн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт, тухайн байгууллагын үндсэн ажилтан байх /E-mongolia лавлагаа/; • Ажилтнууд Эрүүл мэндийн үзлэгт орсон, эрүүл мэндийн дэвтэртэй байх • Талбай түрээслэх үнийн саналыг албан бичгээр ирүүлэх • Түрээслэх хэсгийн орчин нөхцлийг сайжруулах засварын болон эмнэлгийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтран ажиллах санал ирүүлэх • Сонгон шалгаруулалтын үнийг олон нийтэд ил мэдээллэхэд татгалзах зүйлгүй тухай албан мэдэгдэл ирүүлэх • Талбайн өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ, зохион байгуулалтын үйл ажиллагааг хариуцах тухай албан бичиг ирүүлэх. • Сонгон шалгаруулалтанд оролцох хураамж 50,000 /тавин мянга/ төгрөг тушаах ба тушаасан баримтыг бүрдүүлж буй бичиг баримтанд хавсаргах /Данс Төрийн сан 100900020015/
--	--

4. Түрээслэгчийг сонгон шалгаруулах зааврын талаарх товч мэдээлэл

1. Үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн, туршлагатай, санхүүгийн чадвартай гэдгээ оролцогч өөрөө нотлох зорилгоор бүрдүүлэх материалыг бүрэн ирүүлнэ.
2. Материал дутуу тохиолдолд үл маргах журмаар хасна.
3. Материалыг бүрэн ирүүлсэн, тавигдах шаардлагыг хангасан нэг оролцогчийг сонгон шалгаруулна.

5. Мэдээлэл авах

Эд хөрөнгөтэй холбоотой нэмэлт мэдээллийг өмч эзэмшигч ЭХЭМҮТ дээр очиж үзэж болох бөгөөд сонгон шалгаруулалтын заавар, бүртгэх хугацаа, хөрөнгийн талаарх мэдээллийг **99231523** утсаар болон www.ehemut.mn, www.pcsp.gov.mn цахим хуудаснаас авна уу.

Хаяг: БГД, 11-р хороо, Хувьсгалчдын гудамж, ЭХЭМҮТ